

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/71/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ЦЭВЭЛМАА ТАНАА

2021.02.25 № 4/38
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод, хариуцлагатай байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Эд хөрөнгийн толлого хийж, тооцоо бодоогүй, төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, зардлыг бүлэг хооронд болон бүлэг дотор гүйлгэн зарцуулснаар санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй, зарим зардлын хүлээн зөвшөөрөлт, бүртгэл тайлагнал зөрүүтэй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

121020651

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,655,676.25	38,672,974.71
33	АВЛАГА	782,442.54	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	782,442.54	-
35	БАРАА МАТЕРИАЛ	41,873,233.71	38,672,974.71
354	Хангамжийн материал	41,517,733.71	38,317,474.71
35410	Бичиг хэргийн материал	3,428,394.04	6,278,945.04
35420	Аж ахуйн материал	25,919,129.67	28,016,429.67
35470	Бусад хангамжийн материал	12,170,210.00	4,022,100.00
35600	Мал амьтад	355,500.00	355,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	801,061,027.22	1,910,008,476.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	801,061,027.22	1,910,008,476.13
392	Биет хөрөнгө	776,554,827.22	1,884,564,776.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	910,698,030.86	2,032,123,556.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(228,971,384.50)	(290,104,604.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	144,585,000.00	144,585,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,927,812.41)	(97,684,895.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,595,567.00	127,527,736.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,823,606.20)	(64,822,911.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,433,831.54	55,433,831.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,085,827.07)	(23,543,964.02)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,051,028.00	1,051,028.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,540,000.00	1,540,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,000.00)	(1,540,000.00)
393	Биет бус хөрөнгө	24,506,200.00	25,443,699.96
39301	Програм хангамж		1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(312,500.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,506,200.00	24,506,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	843,716,703.47	1,948,681,450.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	843,716,703.47	1,948,681,450.84
51	Засгийн газрын хувь оролцоо	843,716,703.47	1,948,681,450.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	607,714,368.00	607,714,368.00
51101	Өмч: - төрийн	607,714,368.00	607,714,368.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,117,364.51	1,112,082,111.88
51210	Өмнөх үеийн үр дүн	7,117,364.51	6,710,576.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,105,371,535.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,884,970.96	228,884,970.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	843,716,703.47	1,948,681,450.84

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	459,354,601.00	1,657,311,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,042,500.00	1,116,577,788.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,042,500.00	1,116,577,788.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,042,500.00	1,116,577,788.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,437,500.00	1,115,972,788.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,312,101.00	540,733,447.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,164,001.00	74,428,847.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,458,500.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	5,526,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,800,000.00	68,257,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,905,501.00	645,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	359,148,100.00	466,304,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,990,200.00	451,684,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30,157,900.00	14,620,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	416,277,612.77	551,939,699.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,277,612.77	551,939,699.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,582,212.77	479,172,499.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,435,150.64	231,721,262.00
210101	Үндсэн цалин	137,331,950.64	193,495,491.00
210102	Нэмэгдэл	37,415,900.00	33,188,207.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,687,300.00	5,037,564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,265,400.00	27,986,935.83
210201	Тэтгэврийн даатгал	16,500,500.00	19,230,715.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,941,300.00	2,262,437.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,553,000.00	1,809,949.66
210204	Ажилгүйдлийн даатгал	388,200.00	423,215.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,882,400.00	4,260,618.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,477,600.00	20,502,593.00
210301	Гэрэл, цахилгаан	3,442,200.00	2,345,693.00
210302	Түлш, халаалт	18,035,400.00	18,156,900.00

2104	Хангамж, бараа материалын зардал	23,612,599.01	33,129,561.00
210401	Бичиг хэрэг	4,878,098.01	4,376,956.00
210402	Тээвэр, шатахуун	14,290,601.00	21,010,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	2,919,000.00
210404	Ном, хэвлэл	-	4,594,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	229,500.00
2105	Нормативт зардал	402,000.00	126,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	126,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,637,200.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	3,437,200.00	
2107	Томилолт, зочны зардал	7,200,500.00	1,135,000.00
210702	Дотоод албан томилолт	7,200,500.00	1,135,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,738,500.00	23,605,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,801,500.00	22,771,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	270,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234,000.00	303,777.00
210807	Газрын төлбөр	138,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,813,263.12	140,765,701.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,374,560.00	38,105,455.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,438,703.12	102,660,246.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,695,400.00	72,767,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,695,400.00	72,767,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,420,400.00	34,987,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	37,780,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	43,076,988.23	1,105,371,535.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,247,400.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,247,400.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,247,400.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,829,588.23	1,105,371,535.08

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	412,917,101.00	541,338,447.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	605,000.00	605,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	605,000.00	605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	605,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,312,101.00	540,733,447.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,157,900.00	14,620,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	30,157,900.00	14,620,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,164,001.00	74,428,847.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,458,500.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	5,526,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,800,000.00	68,257,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,905,501.00	645,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,990,200.00	451,684,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,990,200.00	451,684,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	373,117,101.00	442,081,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,117,101.00	442,081,440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,421,701.00	368,477,140.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,124,000.00	228,641,123.00
210101	Үндсэн цалин	138,020,800.00	156,569,600.00
210102	Нэмэгдэл	37,415,900.00	45,461,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,687,300.00	26,610,023.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,265,400.00	30,337,777.00
210201	Тэтгэврийн даатгал	16,500,500.00	21,175,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,941,300.00	2,281,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,553,000.00	1,825,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	388,200.00	562,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,882,400.00	4,493,377.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,477,600.00	21,555,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,442,200.00	3,687,200.00

210302	Түлш, халаалт	18,035,400.00	17,868,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,933,501.00	29,920,639.00
210401	Бичиг хэрэг	3,199,000.00	3,580,284.00
210402	Тээвэр, шатахуун	14,290,601.00	14,630,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	3,443,900.00
210404	Ном, хэвлэл	-	8,265,500.00
2105	Нормативт зардал	402,000.00	372,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	372,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,637,200.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	3,437,200.00	
2107	Томилолт, зочны зардал	7,200,500.00	1,135,000.00
210702	Дотоод албан томилолт	7,200,500.00	1,135,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,738,500.00	25,764,901.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,801,500.00	24,686,801.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	266,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234,000.00	375,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,643,000.00	30,549,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,643,000.00	30,549,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,695,400.00	73,604,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,695,400.00	73,604,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,420,400.00	34,987,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	38,617,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,800,000.00	99,257,007.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,800,000.00	99,257,007.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,800,000.00	99,257,007.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,800,000.00	99,257,007.00
222001	Тоног төхөөрөмж	39,800,000.00	33,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		66,257,007.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(39,800,000.00)	(99,257,007.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	(57,045,433.37)	779,553,905.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	22,333,209.65	22,333,209.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	(34,712,223.72)	801,887,115.24
Тайлант үеийн үр дүн	-	-	41,829,588.23	41,829,588.23
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	7,117,364.51	843,716,703.47
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	7,117,364.51	843,716,703.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(406,787.71)	(406,787.71)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	6,710,576.80	843,309,915.76
Тайлант үеийн үр дүн	-	-	1,105,371,535.08	1,105,371,535.08
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	1,112,082,111.88	1,948,681,450.84

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ЭЗА	Зардлын ангилал	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,402,200.00	466,909,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,402,200.00	433,909,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,722,900.00	360,305,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,175,200.00	228,175,200.00
210101	Үндсэн цалин	156,569,600.00	156,569,600.00
210102	Нэмэгдэл	45,461,500.00	45,461,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,144,100.00	26,144,100.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,803,700.00	30,803,700.00
210201	Тэтгэврийн даатгал	21,676,700.00	21,676,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,281,700.00	2,281,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,400.00	1,825,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	456,400.00	456,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,563,500.00	4,563,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,555,900.00	21,555,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,687,200.00	3,687,200.00
210302	Түлш, халаалт	17,868,700.00	17,868,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,350,400.00	29,350,400.00
210401	Бичиг хэрэг	3,199,000.00	3,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,442,000.00	14,442,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	3,443,900.00
210404	Ном, хэвлэл	8,265,500.00	8,265,500.00
2105	Нормативт зардал	372,000.00	372,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	372,000.00	372,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,135,000.00	1,135,000.00
210702	Дотоод албан томилолт	1,135,000.00	1,135,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,875,900.00	22,458,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,788,900.00	21,380,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	266,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	375,000.00	375,000.00
210807	Газрын төлбөр	147,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,254,800.00	26,254,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,254,800.00	26,254,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,679,300.00	73,604,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,679,300.00	73,604,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,987,200.00	34,987,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,692,100.00	38,617,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,000,000.00	33,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,000,000.00	33,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	33,000,000.00	33,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,402,200.00	466,909,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	467,797,200.00	466,304,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	453,177,200.00	451,684,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	14,620,000.00	14,620,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00

620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,428,847.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,171,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,171,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	570,239.00
210401	Бичиг хэрэг	381,284.00
210402	Тээвэр, шатахуун	188,955.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,306,601.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,306,601.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,295,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,295,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,257,007.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,257,007.00
221001	Их засвар	47,257,007.00
222001	Тоног төхөөрөмж	19,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,428,847.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,428,847.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,526,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,257,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	645,000.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Н.Цэвэлмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн зарцуулалт, хууль, тогтоомжийн хэрэгжилт, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 16-наас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газар нь “Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, ил тод, шуурхай байдлыг хангаж, төр иргэдийн холбоог бэхжүүлэн сум орноо хөгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Сумын Засаг даргын Тамгын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

1. Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах
2. Төрийн хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх
3. Сумын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах
4. Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам,
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 оны 4 дүгээр сард хяналт шалгалт хэрэгжүүлжээ. Тус хяналтаар ажилтан албан хаагч, хувь хүмүүс, байгууллагатай холбогдсон 4587.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7800.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооцоо данс бүртгэлд тусгахыг даалгасан байна.

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө дунд гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 404098.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4041.0 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 551939.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5519.4 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1104964.7 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
33	Авлага	782.4	-	(782.4)
35	Бараа материал	41,873.2	38,673.0	(3,200.3)
39	Үндсэн хөрөнгө	801,061.0	1,910,008.5	1,108,947.4
3	Нийт хөрөнгийн дүн	843,716.7	1,948,681.5	1,104,964.7
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	843,716.7	1,948,681.5	1,104,964.7
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	843,716.7	1,948,681.5	1,104,964.7

Авлагын дансны оны эхний үлэгдэл 782.4 мянган төгрөгийн 602.3 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт, 180.1 мянган төгрөг нь өмнөх онд нягтлан бодох бүртгэлийн алдаанаас ажиллагчидтай холбоотой авлага бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 602.3 мянган төгрөгийн НДШ-ийн тооцооны авлагыг барагдуулж, 180.1 мянган төгрөгийн авлагыг залруулж, оны эцэст авлага үүсгээгүй байна.

Бараа материалын данс оны эхэнд 41873.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 3200.2 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 38673.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	41,873.2
2	Нэмэгдсэн	38,809.8
2.1	Худалдан авсан	35,187.7
2.2	Хандиваар	3,622.1
3	Хасагдсан	42,010.1
3.1	Худалдсан, зарцуулсан	42,010.1
4	Эцсийн үлдэгдэл	38,673.0

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1176409.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1211607.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 2388017.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Оны эцэс дэх эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүн нь хуримтлагдсан элэгдлийг хассанаар 1910008.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	1,176,409.7
2	Нэмэгдсэн	1,211,607.7
2.1	Худалдан авсан	99,257.0

2.5	Бусад	1,112,350.7
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,388,017.4
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	375,348.6
8	Элэгдлийн зардал тайлант хугацааны	102,660.2
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	478,008.9
11	Үлдэгдэл өртөг	1,910,008.5

Тайланд онд нэмэгдсэн 1211607.7 мянган төгрөгийн хөрөнгөөс 1112350.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 99257.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч данс бүртгэлд тусгасан байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг дэлгэрэнгүй харуулбал:

- Аймгийн ОНХС-аас 1250.0 мянган төгрөгийн программ хангамж,
- Сумын ОНХС-аас 9000.0 мянган төгрөгийн автомат худгийн тоног төхөөрөмж,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1102100.6 мянган төгрөгийн нутгийн удирдлагын ордны барилга байгууламж,

Биет бус хөрөнгөд 1250.0 мянган төгрөгийн өртөгтэй, 312.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж, 7 байршилд нийт 24506.2 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 607714.3 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1197956.6 мянган төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН			
		459,354.6	1,657,311.2	1,197,956.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	605.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,437.5	1,115,972.8	1,069,535.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,164.0	74,428.8	21,264.8
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,990.2	451,684.6	122,694.4
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30,157.9	14,620.0	(15,537.9)

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 1115972.8 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн төсвийн санхүүжилт өмнөх оноос 122694.4 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 135662.1 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН			
		416,277.6	551,939.7	135,662.1
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,582.2	479,172.5	89,590.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,435.2	231,721.3	38,286.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,265.4	27,986.9	3,721.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,477.6	20,502.6	(975.0)

2104	Хангамж, бараа материалын зардал	23,612.6	33,129.6	9,517.0
2105	Нормативт зардал	402.0	126.0	(276.0)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,637.2	200.0	(3,437.2)
2107	Томилолт, зочны зардал	7,200.5	1,135.0	(6,065.5)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,738.5	23,605.4	(15,133.1)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,813.3	140,765.7	63,952.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,695.4	72,767.2	46,071.8

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 42007.6 мянга, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 67221.5 мянга, урсгал шилжүүлгийн зардал 46071.8 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Дээрх зардлууд өссөн шалтгаан нь

- Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн,
- Шинэ нутгийн удирдлагын ордон ашиглалтад орсноор тайлант хугацааны элэгдлийн зардал өссөн,
- 3 ажилтан, албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарснаар урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны үзүүлэлтээс тус тус материаллаг хэмжээгээр өсчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд 406.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаанд залруулга хийсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 470890.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 470890.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2488.0 мянган төгрөгөөр бууруулж 468402.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 111821.3 мянган төгрөгөөр өсчээ. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 40589.5 мянга, хангамж бараа материалын зардал 10617.3 мянга, урсгал шилжүүлгийн зардал 47258.9 мянга, хөрөнгийн зардал 33000.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь материаллаг буюу гол нөлөө үзүүлжээ

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 468402.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 453177.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14620.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 451684.6 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 14620.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанаас 605.0 мянган төгрөгийн орлого, нийт 466909.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466909.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь төсвийн санхүүжилт 1492.6 мянган төгрөгөөр дутуу авснаас шалтгаалжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
70106	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	223,287.4	223,102.2	-185.2
70106	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	12,240.0	12,240.0	0.0
70106	80106	Баг, хорооны ҮАЗардал	79,307.3	79,221.0	-86.3
70106	80205	Мэдээлэл, сурталчилгааны зарда	4,553.4	3,424.9	-1,128.5
70106	80305	Биеийн тамирын уралдаан, тэмцэ	223.0	223.0	0.0
70106	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	73,504.3	73,504.3	0.0
70106	80918	Бусад	33,000.0	33,000.0	0.0
70106	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	4,500.0	4,500.0	0.0
70106	82212	Хур хог хаягдал, орчны бохирдл	1,000.0	907.4	-92.6
70106	82801	Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0
70801	82502	Мал эмнэлгийн ?йлчилгээ	14,620.0	14,620.0	0.0
71413	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхө	16,286.8	16,286.8	0.0
72208	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	160.0	160.0	0.0
72208	80221	Гэрээт ажиллагсдын зардал	720.0	720.0	0.0
			468,402.2	466,909.6	-1,492.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 68257.0 мянга, бусад шатны төсвөөс 5526.8 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох хууль, журмын хүрээнд бүрдүүлж, 645.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн орлогыг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан зөрчилд зөвлөмж өглөө.

Дээрх 73783.8 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд зарцуулж, 645.0 мянган төгрөгийн орлогыг зориулалт бусаар зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байна. тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан хэрэгжүүлжээ. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн тайланд тус байгууллагатай холбогдсон 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2150.0	1	2150.0	-	-	100%
Нийт дүн	1	2150.0	1	2150.0		-	100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 99861.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66663.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2244.5 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 645.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 30308.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд НДШ, ажиллагчидтай холбогдсон 406.8 мянган төгрөгийн авлага илүү бүртгэсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй орлого, хөрөнгийн зардлыг 66257.0 мянган төгрөгөөр давхардуулан бүртгэсэн

Нийт 66663.8 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулаа хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар дараах залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд тухайн онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын ажилтан албан хаагч, бусад хувь хүмүүстэй холбоотой төлбөрийн актаас 1944.5 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөс барагдуулсан, түүнчлэн сумын төвийн хог цэвэрлэх, хогийн цэг засварлах ажлын санхүүжилтийг няравын дансаар дамжуулан олгосон боловч гүйцэтгэгчид 300.0 мянган төгрөгийг дутуу олгосон, тухайн ажлыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн аваагүй зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Дараах зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвийн хүү торгуулийн орлого 645.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан, түүнчлэн эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, малын нас дэвшил, өөрчлөлтийн бүртгэл тооцоо хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана”, 23 дугаар зүйлийн 23.9.3-д “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого нь хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлогоос

бүрдэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 30308.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах асуудалд гүйцэтгэлийн үе шатанд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, шийдэл гаргах нөхцөл боломж цаг хугацааны хувьд хүрэлцээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Тус сургууль 2020 онд Вивазоне ХХК-ийн нэгдсэн халаалтын системээс дулааны эрчим хүчээр хангагдсан. Тухайн жилд ЗДТГ-ын барилгын халаалтын төсөв 15551.3 мянган төгрөг байхад Вивазоне ХХК-тай халаалтын үйлчилгээ авахаар 52438.6 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Гэвч хоорондын тооцоо нийлсэн актаар 36887.3 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй,
- Бараа материал, шатахууны зарцуулалт, цалин хөлсний тооцоололд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу "Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар зардлын эдийн засгийн ангилал баталсан шийдвэртэй тус тус нийцүүлэн төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн зарцуулалттай холбоотой

2.1. Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын журам зөрчигдөх, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана" гэсэн заалттай нийцүүлж, сар бүрийн батлагдсан төсвийн 30-аас доошгүй хувийн нөөцийг бүрдүүлж, зориулалтын арга хэмжээнд зарцуулах бэлэн байдлыг хангаж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

3.1. Илрүүлэлт: Гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэсний хөлснөөс НДШ, ХХОАТ суутган төсөвт төвлөрүүлж тайлагнаагүй.

3.2. Эрсдэл: Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй

3.3. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нийцүүлэн дээрх ажил, үйлчилгээний хөлснөөс НДШ, татвар суутган тооцож төсөвт шилжүүлэн, тайлагнах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

4.1. Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөс ном худалдан авахад 5690.0 мянган төгрөг зарцуулсан боловч 3040.0 мянган төгрөгийн ном орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн. Түүнчлэн дээрх зардалд зарцуулсан хөрөнгийн үр дүн, ач холбогдол нь тодорхой бус байна.

4.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр дүнгүй, хяналтгүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлтэй

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "Төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллана" гэсэн заалтуудтай нийцүүлж, төсвийн хөрөнгийг үр дүн, үр өгөөжтэй зарцуулж, зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/71/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 1944.5 мянган төгрөгийн актын төлбөрийг зохих хууль, эрхзүйн дагуу барагдуулаагүй	1944.5	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
2	С.Пүрэвсүрэн сумын төвийн хогийн цэгийн хашааны тор засварлах, сумын төвийн хог цэвэрлэх ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгоогүй	300.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
3	Орон нутгийн төсвийн хүү торгуулийн 645.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан.	645.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
4	Эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй. Малын нас дэвшил, өөрчлөлтийн бүртгэл тооцоо байхгүй	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
5	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.	17104.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
6	НДШ-ийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 344.4 мянган төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд 2608.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Цалин хөлсний татварын тайлангийн тооцоо үлдэгдэл зөрүүтэй	2953.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай

7	Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.	1350.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
8	Гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэсний хөлснөөс НДШ, ХХОАТ суутган төсөвт төвлөрүүлж тайлагнаагүй.	3210.3	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
9	Төсвийн хөрөнгөөс ном худалдан авахад 5690.0 мянган төгрөг зарцуулсан боловч 3040.0 мянган төгрөгийн ном орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн. Түүнчлэн дээрх зардалд зарцуулсан хөрөнгийн үр дүн, ач холбогдол нь тодорхой бус байна.	5690.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
10	Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй орлого, хөрөнгийн зардлын данс 66257.0 мянган төгрөгөөр давхардуулан бүртгэсэн	66257.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
11	Тайлант хугацаанд НДШ, ажиллагчидтай холбогдсон 406.8 мянган төгрөгийн авлага илүү бүртгэсэн	406.8	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Цэвэлмаа Б.Баяндалай
ДҮН		99861.3			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР